



# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

## ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

### ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

## **НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

*2023 оны 06 дугаар сарын 13-ны өдөр, Мягмар гараг*

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	<b>1</b>
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	<b>2-5</b>
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	<b>6-20</b>
<hr/>	
<i>1.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/</i>	<b>6-14</b>
<i>2.“Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/</i>	<b>14-18</b>
<i>3.“Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/</i>	<b>18-20</b>

***Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 06 дугаар  
сарын 13-ны өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл***

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 17 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.*

*Чөлөөтэй: Н.Алтанхуяг, П.Анужин, Б.Дэлгэрсайхан, Д.Цогтбаатар;  
Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Сэргэлэн.*

***Нэг.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн ахлах шинжээч Д.Отгонжаргал, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн мэргэжилтэн Б.Дашням, Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн Ж.Төгөлдөр, Э.Цолмон, Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн Н.Уранцэцэг, Б.Дэнсмаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Тунгалагтамир, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, мөн яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга Ч.Гандирваа, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Оюунгэрэл, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, мөн яамны Төрийн захиргаа удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Ганбат, Оцгой байдлын ерөнхий газрын дэд дарга Д.Намсрай, мөн газрын Санхүү, ар талын газрын

Төсөв санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга М.Хаш-Эрдэнэ, Цөмийн энергийн комиссын Нарийн бичгийн дарга Г.Манлайжав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Төсвийн төслийн талаар Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Н.Наранбаатар нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Хуралдааныг 15 цаг 57 минутад Батлан хамгаалахын сайдын мэдээллийг сонсохоор хаалттай горимд шилжүүлэв.*

*Хуралдааныг 16 цаг 37 минутад нээлттэй горимд шилжүүлэв.*

***Хоёр. “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа, мөн газрын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны дарга П.Ганболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хуулийн төслийн талаар Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, төслийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Э.Бат-Амгалан нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баделханы тавьсан асуултад Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт хариулж, тайлбар хийв.

**Б.Энх-Амгалан:** “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 16 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав.** “Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа, мөн газрын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны дарга П.Ганболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хуулийн төслийн талаар Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, төслийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Э.Бат-Амгалан нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Б.Энх-Амгалан:** “Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны нээлттэй хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 23 минут үргэлжилж, 16 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр 16 цаг 50 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 06 дугаар сарын 13-ны өдөр,  
Мягмар гараг Төрийн ордон “Их засаг”  
танхим 15 цаг 17 минут

### БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Б.Энх-Амгалан:** Байнгын хорооны хорооны хуралдааны ирцийг та бүхэнд танилцуулъя. Б.Энхамгалан ирсэн, Норовын Алтанхуяг чөлөөтэй, Амартүвшин гишүүн ирсэн, П.Анужин гишүүн чөлөөтэй, Бат-Амгалан гишүүн ирсэн, Баттөмөр гишүүн ирсэн, Х.Баделхан гишүүн ирсэн, С.Батболд гишүүн хаачсан юм. Батболд гишүүнийг дуудаарай. Б.Бат-Эрдэнэ гишүүн ирсэн, Д.Ганбат гишүүн алга байна. Хуралдаа оролц гэж дуудаарай. Дэлгэрсайхан гишүүн чөлөөтэй байна. Наранбаатар гишүүн ирсэн байна. Сэргэлэн гишүүн өвчтэй байна. Цогтбаатар гишүүн чөлөөтэй байна. Нямаагийн Энхболд гишүүн ирсэн байна. Ж.Эрдэнэбат гишүүн ирсэн байна.

Ингээд байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 6 сарын 13-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье ээ.

Өнөөдрийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Ажлын хэсгийг уриарай.

1.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, Засгийн газар 2023 оны 6 сарын 8-ны өдөр өргөн мэдүүлсэн 2 дахь

хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

2.Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хуулийн төсөл, Засгийн газар 2023 оны 5 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах.

3.Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенцод нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төсөл, Засгийн газар 2023 оны 5 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах.

4.Батлан хамгаалахын сайдын мэдээллийг сонсох, хаалттай.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу? Алга байна.

Ажлын хэсэг байраа эзэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг та бүхэнд танилцуулъя.

Болдын Жавхлан Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Сангийн сайд. Жавхлан сайдыг дуудаарай. Хүрэлбаатарын Булгантуяа Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Доржсүрэнгийн Занданбат Монгол Улсын ерөнхий аудитор, Саркетын Зулхар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд, Цэвэгсүрэнгийн Наранчимэг Монгол Улсын ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ядамын Самбууням Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор, Дэлгэрийн Энхболд Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Жигжидийн Ганбат Сангийн яамны ТНБД, Минжидийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Баасангийн

Батжаргал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын Бодлого, зохицуулалтын газрын дарга, Сандагийн Тунгалагтамир Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Лувсанвандангийн Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Дангаасүрэнгийн Отгонжаргал Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн ахлах шинжээч, Жаргалсайханы Төгөлдөр Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн, Энхболдын Цолмон Сангийн яамны төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн, Ням-Осорын Уранцэцэг Сангийн яамны төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн, Батхишигийн Дашням Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн мэргэжилтэн, Бүдрагчаагийн Дэнсмаа Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн, Батлан хамгаалах яам Гүрсэдийн Сайханбаяр Батлан хамгаалахын сайд, дэслэгч генерал, Дагвадоржийн Ганхуяг БХЯ-ны ТНБД Бригадын генерал, Сүнрэвийн Ганбямба ЗХЖШ-ын дарга, бригадын генерал, Чулуунборын Гандирваа БХЯ-ны Стратеги бодлого төлөвлөлтийн газрын дарга хурандаа, Бадраагийн Оюунгэрэл Тус яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга дэд хурандаа, Гадаад харилцааны яам Нямдоржийн Анхбаяр ГХЯ-ны ТНБД, Чүлтэмийн Ганбат ГХЯ-ны Төрийн захиргаа удирдлагын газрын Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга, ОБЕГ Думаагийн Намсрай ОБЕГ-ын дэд дарга хурандаа, Намсрай хурандааг дуудаарай. Мягмаржавын Хаш-Эрдэнэ ОБЕГ-ын Санхүү ар талын газрын Төсөв, санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, хурандаа, Цөмийн энергийн комисс Гунаажавын Манлайжав Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга ажлын хэсгийн гишүүдийг танилцуулж дууслаа.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүн Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Жавхлан сайдын микрофоныг өгье.

**Б.Жавхлан:** Эрхэм байнгын хороон дарга эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас экспортыг эрчимжүүлж гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх эдийн засгийг сэргээхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай авсны үр дүнд эдийн засаг 2023 оны 1 дүгээр улиралд 7.9 хувиар өсөж гадаад валютын албан нөөц энэ оны эхний 5 сарын байдлаар 3.8 тэрбум амдолларт хүрч сайжраад байна. Хэдийгээр эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд эерэг өөрчлөлтүүд гарч эхэлсэн боловч гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр инфляц төдийлөн буурахгүй иргэдийн бодит орлогод нөлөөлж байгаа тул ард иргэдийн орлого амьжиргааг дэмжих зайлиггүй шаардлагыг бий болгож байна. Дээр дурдсан эдийн засаг нийгмийн нөхцөл байдалтай уялдуулан Монгол Улсын Засгийн газраас иргэдийнх орлогын баталгаа, амьдрах орчныг сайжруулах, хотын түгжрэлийг бууруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төсвийн тодотголын төсөлд тусгалаа.

Тухайлбал хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хүсэлт гаргасан өрхийн хүүхэд бүрд олгохын зэрэгц хүүхдийн мөнгөнөөс хасагдсан өрхийн хүүхдэд нөхөж олгох, тэтгэврийн зөрөөний асуудлыг цалингийн суурь итгэлцүүрийг шинэчлэх замаар шийдвэрлэх, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх. Төрийн албаны цалингийн тогтолцоог



шинэчилж суурь цалингийн хэмжээг нэмэгдүүлэх, нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлж авто замын сүлжээг өргөтгөх зэргээр нийслэлийн түгжрэлийг бууруулах зэрэг арга хэмжээг төсөв хооронд зохицуулалт хийж шийдвэрлэхээр төсвийн тодотголын төсөлд тусгаад байна. Төсвийн тодотголын арга хэмжээний үр дүнд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 1.7 их наяд төгрөгөөр нэгдсэн төсвийн нийт зарлага 1.8 их наяд төгрөгөөр нэмэгдэх бөгөөд нэгдсэн төсвийн нийт алдагдал 1.6 их наяд төгрөг буюу анх батлагдсан 2.6 хувиас хэтрүүлэхгүй байхаар төлөвлөлөө.

Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Б.Энх-Амгалан:** Жавхлан сайдад баярлалаа.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Цэвэгсүрэнгийн Наранчимэг танилцуулна.

3 дугаар микрофоныг өгье.

**Ц.Наранчимэг:** Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу төрийн аудитын байгууллага дараах дүгнэлтийг гаргаж байна. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 20 их наяд 781.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 34.5 хувь, нийт зарлагын хэмжээг 22 их наяд 371.4 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 37.2 хувь, төсвийн алдагдлыг 1 их наяд 589.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2.6 хувь байхаар төлөвлөжээ.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2023 оны төсвийн тодотголд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөвт дараах өөрчлөлтийг оруулсан байна. Гадаад харилцааны сайдын төсөв 2023 оны батлагдсан төсвөөс 6.7 тэрбум, Батлан хамгаалах сайдын төсөв 75.5 тэрбум төгрөгийн өөрчлөлтүүдийг оруулжээ. Төсвийн ерөнхийлөн захирагчдын урсгал зардлын төсөв 82.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд төрийн албан хаагчийн цалин хөлсний системийг шинэчлэн цалинг нэмэгдүүлэн тогтоосон нь гол нь нөлөөлсөн байна. Төрийн аудитын байгууллага Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна гэж дүгнэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Б.Энх-Амгалан:** Наранчимэгийн аудиторд баярлалаа.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны

төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн Ерөнхийлөгчийн захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээс бэлтгэн ирүүлснийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Ингээд хууль санаачлагчаас болон аудитын дүгнэлт, Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөгчийн захирагч нараас асуух асуулттай гишүүд нэрс өгнө үү? Наранбаатар гишүүнээр тасаллаа.

Ганбат гишүүн асуултаа асууя.

**Д.Ганбат:** Ингээд манай Байнгын хорооны одоо хэлэлцэх асуудлын юунд манай энэ аюулгүй байдалд хамрагддаг энэ манай армийнхан бусад ингээд газрууд орж иржээ. Одоо манай цэрэг түрүүч нарын цалин пүнлүү ямар байна вэ? Нөгөө нэг бүтээн байгуулалтад оролцдог барьдаг гээд нэг хэсэг яриад байсан тэр хүмүүс чинь одоо тэр бүтээн байгуулалтынхаа ажлыг хийж байгаа юу, үгүй юү, ямар байгаа вэ? Нөгөө талаар бол сүүлийн үед ЭСЯ-ууд энд тэнд заримыг нь татан буулгаад консулын газруудыг нэлээн байгуулж байгаа. Тэгээд энэтэй холбогдоод хэдэн консулын газар нэмж байгуулагдаад энэ онд одоо хэд ахиад нэмж байгуулах вэ гэсэн нэг ийм асуулт байна. Миний мэдэхийн бараг 10-аад жилийн өмнө тухайлбал Японы ЭСЯ бол нэлээн хүнд байдалд орчихсон байх шиг байсан. Их засвар хийнэ барина гээд л бараг удаа дараа яриад л байдаг байсан. Тэр нь одоо юу болж байгаа юм? Сая бол би тэрүүгээр нэг албаны шугамаар явахдаа гаднын л юугаар явсан л даа. Очиж орж чадаагүй. Байдал нь бол хэвээр байгаа гэсэн ийм зүйлийг л би сонссон. Гэх мэтчилний ийм асуултууд байна. Ялангуяа одоо манай офицерууд маань хэр зэрэг цалин хангамжтай байна вэ?

Энхийг сахиулагчид маань одоо яаж цалинжиж байна, ямаршуухан маягаар явж байна? Энэ юманд одоо тэгээд хамрагдаж байгаа юу ямар байгаа вэ тэ? Тэгээд одоо ер нь нөхцөл байдал манайх одоо хуучин ЗХУ-ын үеийн л тийм зэвсэглэлтэй ийм л байгаа шүү дээ. Наяад оны сүүл хүртэл тэгж явж байсан. Ерээд оноос хойш байдал их өөрчлөгдөж байна, гучаад жил. Манай цэргийн албан хаагчид бол бас тодорхой хэмжээний энхийг сахиулах энэ юманд хамрагдаад гайгүй бас бэлтгэлтэй болоод байгаа байх гэж ойлгож байна. Гэхдээ одоо сүүлийн үед явагдаж байгаа энэ одоо гадна дотнын нөхцөл байдлыг хараад байхад бол юу юугүй манайх руу нэг дайрч орж ирээд ингэх ийм юм нь байхгүй ч гэсэн 19 дүгээр зууны эхээр 20 дугаар зууны эхээр энэ одоо 2 талын их гүрнүүд маань бас арай өөр болчихлоо.

Тухайлбал би ОХУ-ыг хэлэх гээд байна л даа. Тэнд одоо хувийн тийм цэргийн компаниуд бий болчихлоо шүү дээ. Хүнсний цэргүүд. Энэ ч одоо бас наашаа ч ингэж явж байна. Саяхан миний мэдсэнээр бол тэр БХЯ нь зарлиг тушаал гаргаад бүх одоо энэ хүмүүс БХЯ-тайгаа гэрээ байгуул гэж байна. Вагнерынхан бол байгуулахгүй гээд ингээд эхэлж байна. Одоо юмыг яаж мэдэх вэ. Ингээд одоо хойноос ямар нэгэн байдлаар ийм одоо хөлсний цэргүүд ч юм уу тэрэнд татагдах гэсэн зайлсхийсэн яг 2017 он, 2020 оны эхэн үе шиг ингээд наашаа ороод ирж магадгүй ээ. Тэр юманд одоо хэр зэрэг бэлтгэлтэй байна вэ манайхан гэдэг ийм зүйлийг асууж тодруулъя.

**Б.Энх-Амгалан:** Ганбат гишүүний асуултад эхлээд Гүрсэдийн Сайханбаяр Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд, дэслэгч генерал хариулъя.

**Г.Сайханбаяр:** Төрийн нууцтай холбоогүй асуудлаар нь хариулаарай.

2 дахьд нь бол ГХЯ-ны ТНБД Нямдоржийн Анхбаяр хариулъя. Элчин

сайдтай холбоотой асуудлыг нь. Сайханбаяр сайдын микрофоныг өгье. Сайханбаяр генерал та нэг номер дээр очиж суухгүй бол наадах чинь нөгөө карт ороогүй учраас болохгүй байна. Нэг номерын микрофоныг өгье Сайханбаяр сайдын.

**Г.Сайханбаяр:** Байнгын хорооны дарга, гишүүдийнх энэ өдрийн амрыг эрье. Ганбат гишүүний асуултад хариулъя. Бүтээн байгуулалттай холбоотой асуулт асууж байна. Тэгэхээр 2016 онд батлан хамгаалах салбарт эрх зүйн шинэчлэл хийгдэж багц хуулийн шинэчлэл хийгдсэн. Үүнтэй холбоотойгоор Зэвсэгт хүчний тайван цагийн үүрэг нэлээн тэлсэн байгаа. Монгол Улсын Зэвсэгт хүчин стратегийн бүтээн байгуулалтын ажил улс орныг хөгжүүлэх ажилд дэмжлэг үзүүлнэ гэдэг томоохон заалт Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт болж орж ирсэн. Үүнтэй холбогдуулаад энэ барилга инженерийн цэргийг шинээр байгуулсан. Барилга инженерийн цэрэг 2020 оноос албан ёсоор байлдааны тугаа хүлээн авч зохион байгуулалтад орж Засгийн газрын тогтоол шийдвэр гарч ажиллаж эхэлсэн. Үүнээс хойш маш олон бүтээн байгуулалтын ажлыг хийж байна. Өнөөдөр одоо нэлээд олон анги салбар одоо энд бас тоог нь бас байрлалыг нь хамаагүй ярих шаардлагагүй байх. Нэлээд онг олон анги салбарууд үйл ажиллагаагаа явуулж байна. Маш олон бүтээн байгуулалтын ажилд оруулсан. Ер нь зууны хэмжээнд яригдахаар томоохон бүтээн байгуулалтын ажлыг хийсэн. Зүүнбаян-Тавантолгой төмөр замын ажил дээр суурийн ажлыг 100 хувь одоо Монголын зэвсэгт хүчний барилга инженерийн цэргүүд хийсэн. Дэд бүтцийн ажлын 30 хувийг нь хийсэн. Өртөө зөрлөг дэд бүтцийн ажлуудыг нь бүрэн хэмжээнд хийсэн. Ашиглалтад чанарын өндөр түвшинд өгсөн. Мөн Зүүнбаян-Хангийн чиглэлийн замын 216 км төмөр замын ажлын 48 орчим хувийг нь зэвсэгт хүчин дангаараа хийсэн байгаа.

Өнөөдрийн байдлаар бас бүтээн байгуулалтын ажил стратегийн одоо бүтээн байгуулалтын ажилд оролцох оролцоо үргэлжилсээр явж байна. Богд хаан төмөр замын ажлыг эхлүүлчихсэн байж байна. Гашиун сухайтад бид нар ухаалаг терминалын дэд бүтцийг хийж байна. Яг өнөөдөр ажиллаж байна. Зэвсэгт хүчний барилга инженерийн 2 анги тэнд тодорхой бүрэлдэхүүн байрлаад ажиллаж байна. Мөн Хангид ухаалаг терминалын ажлыг мөн хийж байна. Газрын тосны үйлдвэрийн алба хаагчид ажилчдын орон сууцын ажлыг хийж байна.

Ингээд барилга инженерийн цэргийн энэ үндсэн үйл ажиллагаа бол хуульчлагдаж хууль ёсныхоо дагуу Засгийн газрын холбогдох шийдвэр гарч энэ улс орны стратегийн бүтээн байгуулалтын ажилд амжилттай оролцоод явж байгаа. Зэвсэглэл техникийн шинэчлэлтэй холбоотой асуудлыг энэ өнөөдөр хаалттай хуралдаан дээр нэмэлт асуудал ороход энэ дээр нэлээн дэлгэрэнгүй мэдээлэл хийж бас энэ дээр ярих учраас тэр үед мэдээлэл авч болно.

Офицеруудтай холбоотой энэ цалин хөлстэй холбоотой асуудал. Тэгэхээр ер нь батлан хамгаалахын хууль эрх зүйн шинэчлэлийн хүрээнд төрийн цэргийн байгууллагуудын хууль эрх зүйн шинэчлэлийн эхлэл гэдгийг юм уу. Одоо хамгийн түрүүний шинэчлэлийг манайх хийж 2015, 2016 онд шинэчлэл хийж үүний хүрээнд цэргийн албан хаагчдын эрх зүйн байдлын асуудлыг цогцоор нь шийдэж явж ирсэн. Манай шинэчлэлийг дагалдаад төрийн цэргийн байгууллагуудын бусад байгууллагууд энэ одоо хууль эрх зүйн шинэчлэлээ дагалдаж явж ирсэн. Тэгээд өнгөрсөн арваад жилийн хугацаанд энэ төрийн цэргийн байгууллагуудын цалин хөлстэй холбоотой асуудал дээр нэлээн ялгавартай байдал бий болоод тэнцвэр алдагдаад үүрэг гүйцэтгэлтийн онцлог бас тэр бүр одоо ялгагдахгүй тэгсэн

мөртөө олгогдож байсан хэмжэ нь их зөрсөн. Ийм асуудал нэлээн ужгирсан байдалтай явж ирсэн.

Харин одоо энэ Засгийн газрын энэ асуудал дээр бодлого баримталж ялангуяа Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам бол энэ цалин хөлсний төрийн албан.../минут дуусае/.

**Б.Энх-Амгалан:** Сайханбаяр сайдад нэг минут нэмж өгье гүйцээгээд хариулчихъя. Ер нь бол юун дээр 4 дэх асуудал дээр нэлээн дэлгэрэнгүй ярих учраас товчхон хариулчхаарай.

**Г.Сайханбаяр:** Цалин хөлсний энэ шинэчлэлийг үнэхээр одоо төрийн албан хаагчдын цалин хөлсний шинэчлэлийг бүүр реформын шинэжтэй шинэчлэл хийж байна гэж ингэж манай салбарынхан ойлгож байгаа. Хилийн цэрэг өөр, онцгой байдал өөр. Төрийн тусгай хамгаалалт өөр, тагнуулын байгууллага өөр, батлан хамгаалах салбар өөр. Тэгээд энэ эрх зүйн шинэчлэл нь өөр өөр цаг хугацаанд явагдсантай холбогдуулаад эрх зүйн байдлынхаа хууль дээр энэ өөрчлөлтүүдийг оруулах бас энэ өвчин тахалтай холбоотой асуудлаар гамигийн хуулиудад олон удаа нэмэлт, өөрчлөлт оруулах гэх мэтчилний ийм өөрчлөлтүүд нь энэ цалингийн өөрчлөлтийн ялгаврыг ихэсгэхэд одоо нэлээн нөлөө үзүүлсэн байсан. Харин энэ удаагийн төсвийн тодотголоор үнэхээр одоо нэг мөр шийдэж байгаад батлан хамгаалах салбар зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн үнэхээр одоо баяртай байгаа.

Одоо бол офицеруудын цалин, ахлагч нарын цалин, мэргэжлийн цэргийн, албан хаагчдын цалин нэг түвшинд очиж байгаа гэж ингэж ойлгож байгаа.

**Б.Энх-Амгалан:** Баярлалаа. 2 дахь асуудлыг Нямдоржийн Анхбаяр ГХЯ-ны ТНБД хариулъя. 3 номерын микрофоныг өгье.

**Н.Анхбаяр:** Их хурлын гишүүн Ганбат таны асуултад хариулъя. ГХЯ-ны ТНБД Анхбаяр.

Нэгдүгээрт Консулын газар хамгийн сүүлд Чикаго хотод 4 орон тоотой Консулын газар байгуулсан байгаа. 2022 оны 1 сард. Түүнээс хойш бид нар Консулын газар нээгээгүй. Яваандаа төлөвлөгөө юу вэ гэдэг дээр ер нь иргэд байгаа газруудаа бодоод үзэхээр Франц, Тайланд бас ялангуяа зорчих хөдөлгөөн их байна. Ийм учир бас Консулын хэлтэс ЭСЯ-ндаа нэе гэсэн ийм бодол байгаа. Ерөнхий сайдын айлчлалын үеэр Солонгос дахь консулын хэлтсийг бэхжүүлэх чиглэл өгсний дагуу бид нар дотоод нөөц бололцоондоо тулгуурлан өөр газраас орон тоог нь танаад Солонгос дээр нэмж байгаа ийм чиглэл бий. Нөгөө талаасаа яах вэ Узбекистантай харилцан адил байх зарчмын дагуу ерөнхийдөө ЭСЯ байгуулах ийм чиглэл аваад бэлтгэл ажлууд судалгааны ажлууд хийгдэж байгаа. Ийм төлөвлөгөө байна. ЭСЯ-дыг хаасан тухайд бол Индонез, Бразил улсад ажиллаж байсан ЭСЯ-дын үйл ажиллагааг түр зогсоох буюу эдийн засгийн нөхцөл байдал сайжраад ирэхээр буцаагаад сэргээгээд ажиллуулах ийм эрх зүйн бүрэн боломж байгаа. Консулын газрыг нээхээс илүүтэй бид нар үйл ажиллагаагаа цахимжуулах ийм чиглэл рүү түлхүү ажиллаж байна.

Нэгдүгээрт нотариатын үйлчилгээ үндсэнд бүрэн цахимжих шат руугаа явж байна.

Хоёрдугаарт цахим визийг бид нар нэвтрүүлээд одоо бүрэн ажиллаж байна. Төлбөр тооцооных нь системийг сайжруулах гээд сайжруулалтын ажлууд бол хийгдэх шаардлага байгаа. Японы их засварын Японы барилгын нөхцөл байдал хэвээр байгаа. Гэхдээ бид нар уул нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тулгуурлаад хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 2020-2024 оны 5 жилийн төлөвлөгөөнд тусгасан боловч 2021, 2022 он ковидын үндсэндэ жил

хүндрэлтэй байгаад 2023 онд төсвийн төсөлд санал өгсөн. Нөгөө шинээр хөрөнгө оруулалт батлахгүй гэдэг ийм зарчмынхаа хүрээнд явж байгаа. Ер нь яваандаа бол энэ байрны асуудлыг шийдвэрлэх ёстой гэж ойлгож байгаа. Баярлалаа.

**Б.Энх-Амгалан:** Ганбат гишүүн нэг минут тодруулъя.

**Д.Ганбат:** Манай хугацаат цэргийн албан хаагчийн нөхцөл байдал ямар байгаа вэ? Нөгөө өдөрт авах одоо хоол унд тэжээл энэ тэр маань одоо хэдэн төгрөгийн хүрээнд шийдэгдэж байна. Бас цалин гэдэг юм уу урамшуулал гэдэг юм уу тийм зүйл авч байгаа юу үгүй юү? Энэ талаар бас нэг сонирхчихъё гэж бодож байна.

**Б.Энх-Амгалан:** Тодруулаад нэг номер Сайханбаяр генерал хариулъя.

**Г.Сайханбаяр:** Түрүүн бас хугацаа болсон байсан учраас тэр энхийг сахиулагчтай холбоотой асуудлыг бас энэ офицеруудынхаа хүрээнд нэг мөр шийдэж байгаа юм. Офицер ахлагч нарынхаа хүрээнд энэ цалингийн асуудал дээр бодлогын шинэчлэлд бүрэн хамрагдаж байгаа юм. Тэгээд энэ асуудал дээр Сангийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам нэгдсэн бодлого баримталж төрийн цэргийн энэ байгууллагуудын цалин урамшуулалтай холбоотой асуудлыг реформын шинэчлэлээр хийж байгаа гэдгийг бас хэлчихье. Хугацаат цэргийн албан хаагчдын хувьд цалин зөвхөн цолны цалин авдаг. Цолны цалин гэж байгаа. Тэгээд цолны цалин нь бол ТТ-гийн одоо хамгийн бага зэрэглэлийн 10 хувиар авдаг. Энэ нь бол бас тодорхой хэмжээгээр нэмэгдэж байгаа. Яагаад гэвэл зэрэглэл нэмэгдэж байгаатай холбогдуулаад. Үүнээс өмнө өнөөдрийг хүртэлх хугацаанд хугацаат цэргийн албан хаагч 68 мянган төгрөгийн одоо цэргийн цолны цалин авч байсан. Энэ тодорхой хэмжээгээр 100 орчим мянган

төгрөг болж нэмэгдэнэ. Энэ бол хэрэглээний зардал болж байгаа.

**Б.Энх-Амгалан:** Баярлалаа. Наранбаатар гишүүн асуултаа асууя.

**Н.Наранбаатар:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Энэ 2023 оны төсөв батлахад өнгөрсөн жил төрийн албаны хуульд нэмэлт оруулаад орон нутгийн нэмэгдэл 80 хувь хүртэл хувиар олгож болно гээд ингэсэн. Энэ нь одоо хөдөө орон нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчид маш их том боломж бүрдсэн. Тэгэхээр Өмнөговь аймаг бол 80 хувь хүртэл хувиар нэмэгдүүлсэн, улсын төсвөөс 20 хувь гээд ингээд төрийн албан хаагчдын цалин 100 хувь нэмэгдээд явж байгаа юм. Тэгэх дээр Өмнөговь аймагт бас ажиллаж амьдарч байгаа энэ одоо цэргийн байгууллага, энэ тусгай чиг үүрэг гүйцэтгэдэг улсын төсвийн босоо тогтолцоотой байгууллагуудын албан хаагчид энэ 80 хувийн нэмэгдэл нь олгогдох ийм боломжгүй байгаад байгаа юм. Яагаад гэхээр 80 хувь нь орон нутгийн төсвөөсөө нэмнэ гээд ингэчихсэн. Тэгээд нөгөө талаараа бол улсын төсвийн байгууллагын цалин дээр одоо нэмж өгч болохгүй ийм асуудал үүсээд тэгээд тойрогт ажиллаж байхад энэ цэргийн байгууллагуудаас албан хаагчтай уулзчихад энэ хүсэлтийг байнга тавьдаг. Бид яагаад орон нутгийн нэмэгдэл 80 хувь авч болохгүй байгаа юм бэ гэдэг асуудал байнга яригддаг. Тэгэхээр хууль тогтоомжоороо бол энэ нь хаагдчихаад болж өгөхгүй байгаа юм.

Тийм учраас үүнийг нь одоо нээгээд өгөх ийм боломж одоо байна уу үгүй юү. Энэ төсвийн тодотголыг дагаж орж ирж байгаа төрийн албаны хууль бусад хуульд өөрчлөлт оруулаад ингээд энэ босоо тогтолцоотой байгууллагад орон нутгийн нэмэгдэл олох боломжийг нь нээж өгөх ийм одоо боломж байна уу үгүй юү гэж асууя. Өмнөговь аймгийн хувьд бол энэ 2023 оны төсөв дээр улсын

төсөвт төвлөрүүлэх 273 тэрбум төгрөг түүн дээр 180-ыг нэмээд ингээд энэ тодотголоор 456 тэрбум төгрөг улсад төвлөрүүлэхээр одоо тооцогдож орж ирж байна шүү дээ.

Тэгэхээр зэрэг орон нутаг бол бас өөрөө орон нутагт ажиллаж амьдарч байгаа энэ төрийн албан хаагчдаа ялгалгүйгээр орон нутгийн нэмэгдлийг нь өгөх ийм одоо боломж нөөц бололцоо байгаа юм. Тэгээд энэ дээр ямар гарц гаргалгаа байна вэ гэсэн асуулт байна.

**Б.Энх-Амгалан:** Хэн хариулах вэ? Монгол улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд, дэслэгч генерал Сайханбаяр хариулъя. Нэг номерын микрофоныг, Сангийн яам хариулах юм уу? Сангийн сайд Жавхлан Болдын Жавхлан хариулъя. Жавхлан сайдын микрофоныг.

**Б.Жавхлан:** Энэ орон нутгийн төсөв дээр л тодотгол хийх асуудал л даа. Өмнөговь аймаг бол БХЯ-ны харьяа байгууллагууд болон бусад бусад энгийн ТЗ-нүүдийнхийг бол хэвтээнүүдийнхийг Өмнөговь өөрсдөө шийдчихсэн байгаа шүү дээ. Бүүр бусад аймгууд чинь ингээж шийдээгүй ганцхан Өмнөговь аймаг өөрсдөө шийдчихсэн байгаа. Тэгээд тэр жишигээр бас шийдэж болох л асуудал. Тийм орон нутгийн төсөв дээр тавиад тэрийг нь одоо бол ингээд төсвийн нөгөө нэгдсэн тодотгол хийсний дараа орон нутгууд бүгд тодотгол хийж таарна. Нийслэл ч гэсэн яаралтайгаар ингээж хийж таарна. Тэрэн дээр орон нутгууд өөрсдөө хэрвээ боломж байвал энийг нэмээд явах боломжтой тийм. Баярлалаа.

**Б.Энх-Амгалан:** Нямаагийн Энхболд гишүүн асуултаа асууя. Энхболд гишүүний микрофоныг өгье.

**Н.Энхболд:** 2023 оны төсвийн тодотгол ярьж байгаа. Батлан хамгаалах салбарын төсөв амаргүй байгаа. Энэ тодотголоор орж байгаа

нэмэгдлүүдийг тэгээд болж байна гэж үзэж байна уу дутуу юм юу байна. Энэ дээр бол энэ удаа бид нар зөвхөн цалин, тэтгэвэр тэтгэмж, хүүхдийн мөнгө гээд ийм зүйлүүд дээр л хийж байгаа шүү дээ. Өөр ер нь төвөгтэй амаргүй байгааг нь бид нар бүгдээр мэдэж байгаа зөвхөн цалинтай ч холбоотой асуудал биш бусад асуудлууд байгаа. Энийг чухам одоо о ярих юм уу эс үгүй бол дараа нь нөгөө хаалттай хуралдаанаар ярих юм уу ямар ч байсан цалин, тэтгэвэр, тэтгэмжийн хувьд бол одоо энэ орж ирж байгаатай энэ боломжийн гэж үзэж байгаа юу л гэж ганцхан асуулт байна.

**Б.Энх-Амгалан:** Асуултад Сайханбаяр сайд хариулъя. Нэг номерын микрофон.

**Г.Сайханбаяр:** Баярлалаа. Энхболд сайдын асуултад хариулъя ер нь цалинтай холбоотой шийдэл бол болж байна. Үнэхээр бид би бас түрүүн санаагаа хэлсэн. Энэ нэмэгдэл төрийн цэргийн байгууллагуудын хэмжээнд тэр тусмаа одоо зэвсэгт хүчний офицер ахлагч нарын цалингийн энэ байдал дээр бас шинэчлэл болж байгаа. Тэгээд энэ удаагийн төсвийн тодотгол маш үр дүнтэй ийм одоо сайн хууль болж орж ирж байна гэж хэлэх байгаа юм. Энэ дээр ярих юм алга.

Харин асуудал байна манай салбарт. Тэр юу байна вэ гэхээр зэрэг нөгөө хэмнэлтийн хууль батлагдсантай холбогдуулаад зэвсэгт хүчин байнгын одоо үүрэг гүйцэтгэдэг 24 цагийн байлдааны жижүүрлэлтийн үүрэг гүйцэтгэдэг анги салбарууд маш олон байна. Хугацаат цэргийн албан хаагчдын одоо бас асуудлууд байна. Үүнтэй холбоотойгоор хүнсний зардал маш хүнд байгаа. Жанжин штабын дарга 9 дүгээр сараас эхлээд хүнсний асуудал одоо бид нар маш хүнд болох нь гэж байгаа юм. Хугацаат цэргийн албан хаагчдын хүнс хоол дээрээс нь жижүүрлэлтийн бүрэлдэхүүний хүнс хоолны зардал гээд энэ зардал энэ төсөв дээр ям ямар ч одоо

яригдах боломжгүй байсан. Засгийн газрын хуралдаан дээр ч байсан одоо бид бас энэ талаар байр сууриа илэрхийлж байсан. 7.4 тэрбум төгрөгийн асуудал хүнс дээр байгаа.

Мөн Хэмнэлтийн хууль батлагдсантай холбогдуулаад хувцасны зардал бас 70 хувиар танагдсан. Тэгээд энэ жил бол бид бас л одоо бүсээ чангалж байгаа. Энэ хувцасны зардлын асуудал, энэ хүнсний зардлын асуудал нэлээн хүнд байна. Тээвэр шатахууны асуудал байна. Тээвэр шатахуун дээр одоо 5.2 тэрбум төгрөгийн дутагдал үүсэж байгаа. Тэгээд ийм одоо бодит хүндрэлүүд 9 сараас хойш манай дээр үүснэ ээ.

Тэгээд энэ төсвийн тодотголын хуулийг бид нар үндсэн агуулгынх нь хувьд зөвхөн цалинтай холбоотой төрийн албан хаагчдын цалингийн нэмэгдэлтэй холбоотой асуудлыг шийдвэрлэж байгаа гэдэг үүднээс манай энэ асуудлууд анхнаасаа дэмжигдээгүй. Харин энэ асуудлыг шийдвэрлэх нөхцөл боломж байна уу гэдгийг бол Сангийн сайдад бас саналаа тавиад ингээд явж байгаа. Төсөв дотроо зохицуулалт хийх боломж гарах нь уу үгүй юү. Ер нь бас нэлээн хүнд байдалтай юм ийм л асуудлууд байгаа.

**Б.Энх-Амгалан:** Тодруулаад Сангийн сайд нэмэлт тайлбар өгье. Асуултад хариулъя, Сангийн сайдын микрофон Жавхлан сайдын микрофоныг өгье.

**Б.Жавхлан:** Түрүүний Наранбаатар гишүүний асуудал дээр зүгээр нэмээд тодруулж хэлэхэд одоо ингээд хэдүүлээ төсвийн тодотголоо баталчих юм бол маш яаралтай дараагийн Засгийн газрын хуралдаанаар нөгөө цалингийн табицаа батална задалж. Тэр үед орон нутаг босоог нь ч хэвтэйг нь ч аль алиныг нь нэмэх боломжийг нь журам дээр нь дахиад тодруулаад өгөөд оруулчхаж болох юм байгаа шүү. Тийм тэрийг хэлээгүй орхисон байна. Сайханбаяр сайдын

асуулт дээр нэмж хэлэхэд энэ удаа бол тодотголоор бид 5 асуудлаар л Засгийн газраар хэлэлцээд оруулж ирж байгаа тэ. Тэрнээс халихгүй байгаа. Тийм учраас бусад урсгал зардал бусад одоо асуудлуудыг болбол тодотголоор бүгдийг нь шийдэх боломжгүй. Бүх салбар л асуудалтай байгаа. Харин сайд өөрийнхөө төсвийн Ерөнхийлөн захирагчийн хувьд одоо зардлууд дотроо зохицуулалт хийх боломж гарвал Тусгай хяналтын дэд хороогоор ярих нь зөв байх.

**Б.Энх-Амгалан:** Энэ асуудлыг дараа нь Тусгай хяналтын дэд хороогоор ярина. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Улсын Их Хурлын гишүүдээс хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан ирүүлсэн зарчмын зөрөөтэй санал байхгүй тул санал хураалт явахгүй.

Төсвийн тодотголтой холбоотой асуудлаар Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Төсвийн тодотголын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хийсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Амартүвшин танилцуулъя. Төсвийн байнгын хороон дээр. Баярлалаа. Ажлын хэсэгт баярлалаа.

15.52 цагт

Дараагийн асуудалдаа орёё. Дараагийн асуудалтай холбогдуулан ажлын хэсгийг оруулъя.

Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протоколыг соёрхон

*батлах тухай хуулийн төслийг хэлэлцье ээ.*

*Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт. Бямбацогт сайд хаана байна? Байхгүй бол асуудал хойшлогдоно шүү. Доржсийн Эрдэнэбат Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөх, Сүхээгийн Мяндасмаа ЗТХЯ-ны Хуулийн хэлтсийн дарга, Чимэддоржийн Мөнхтуяа ИНЕГ-ын дарга, Пүрэвжавын Ганболд ИНЕГ-ын Нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт зохицуулалтын албаны дарга эдгээр хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирсэн байна. Танилцуулж дууслаа.*

*Сайдаа дуудчих. Хэрвээ сайд чинь байхгүй бол энэ асуудал хойшиллоо. Яасан Мөнгөө холбогдож байна уу? Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Засгийн газрын гишүүн нь байхгүй учраас энэ асуудал хойшиллоо.*

*Дараагийн асуудал Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэгдэл протоколыг соёрхан батлах тухай асуудал байна. Энэ асуудал бас Зам, тээврийн сайдын оруулж ирэх асуудал учраас байхгүй байгаа учраас хойшиллоо.*

*4 дэх асуудалдаа оръё. Дараагийн асуудал ажлын хэсгийг оруулъя.*

*Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22.2-т хаалттай хэлэлцэхээр хуульд заасан болон төрийн нууцтай холбоотой асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ гэж. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 5.1.1-д төрийн нууц гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан задруулах үрэгдүүлэх тохиолдолд үндэсний аюулгүй байдал үндэсний ашиг сонирхолд аюул занал, хохирол учруулах, төрийн хамгаалалтад*

*байх мэдээллийг гэж 13.1-д төрийн нууцад дараах мэдээллийг хамааруулна 13.1.3-т батлан хамгаалах хүрээнд батлан хамгаалах бодлого төрийн цэргийн номлолын нууцлал, зохих мэдээлэл, зэвсэгт хүчний тайван цагийн зохион байгуулалт, бүтэц, тэдгээрийн байлдах чадвар, байлдааны бэлэн байдлыг тодорхойлсон нэгдсэн үзүүлэлт, мэдээлэл хамрагдаж ингэж заасны дагуу Батлан хамгаалахын сайдын мэдээллийг Байнгын хорооны хуралдаанаар хаалттай сонсоно. Хуралдааныг хаалттай горимд эхэлж шилжүүлъя.*

*Ажлын хэсгийг оруулъя. Хуралдаан нээлттэй горимд шилжчихсэн үү? Шилжсэн.*

*Дараагийн асуудалд оръё.*

*Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцье ээ.*

*Хуралдаанд оролцож байгаа, хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг танилцуулъя.*

*Сандагийн Бямбацогт сайд Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд, Доржсийн Эрдэнэбат Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөх, Сүхээгийн Мяндасмаа ЗТХЯ-ны Хуулийн хэлтсийн дарга, Чимэддоржийн Мөнхтуяа ИНЕГ-ын дарга, Пүрэвжавын Ганболд ИНЕГ-ын Нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт зохицуулалтын албаны дарга эдгээр хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирсэн байна.*

*Хуулийн төслийн танилцуулгыг одоо талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт танилцуулна.*



*Бямбацогт сайдын микрофоныг өгье.*

**С.Бямбацогт:** *Байнгын хорооны дарга эрхэм гишүүдийнх өдрийн амгаланг айлтгая аа.*

*Монгол Улс нь агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцод 1971 онд нэгдэн орсон олон улсын иргэний нисэхийн байгууллагын 2010 оны нисэхийн аюулгүй байдлын дипломат бага хурлаас иргэний нисэхийн эсрэг шинэ төрлийн хууль бус үйлдлүүд дэлхий даяар нэмэгдэж байгаатай холбогдуулан Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протоколыг баталж орхигдуулсан зарим шаардлагатай зохицуулалтад нэмж тусгасан.*

*Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол нь 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд одоогоор 35 улс гарын үсэг зурж 21 улс хоёрхон баталж 21 улсад нэгдэн ороод байна.*

*Энэхүү протоколд ашиглалтад байгаа агаарын хөлгийг хууль бусаар булаан авах, хяналтаа тогтоох үйлдэл, оролдлого, оролцооны хэлбэр, хүлээлгэх хариуцлага, гэмт үйлдлийн хамрах хүрээ, харьяалал, ялын байдал, төрийн байгууллагаас авах арга хэмжээ, улс орнуудын хамтын ажиллагааны зохион байгуулалт зэргийг илүү нарийвчлан тодорхойлсон. Монгол Улс нь агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын оролцогч улсын хувьд агаарын тээврийн салбарын хурдацтай өсөлттэй уялдуулан иргэний нисэхийн аюулгүй байдлын түвшин эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор энэхүү протоколыг соёрхон батлах шаардлага үүсээд байна.*

*Агаарын хөлгийг хууль бусаар булаан авахыг хориглох тухай конвенцын нэмэлт протоколыг соёрхон баталснаар улсын төсвөөс нэмэлт зардал шаардахгүй. Харин хуулийн төсөлтэй холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27 дугаар бүлэгт өөрчлөлт оруулах шаардлагатай. Хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.*

*Анхаарал тавьсанд баярлалаа.*

**Б.Энх-Амгалан:** *Хуулийн төсөлтэй холбогдуулан хуулийн төслийн талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Бат-Амгалан гишүүн танилцуулна. Бат-Амгалан гишүүний микрофоныг өгье.*

**Э.Бат-Амгалан:** *Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,*

*Засгийн газар 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай Конвенцын нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг зөвшилцөх хэлэлцүүлэх асуудлыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.4 дэх хэсэгт заасны дагуу Хууль зүйн байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаараа хэлцлээ.*

*Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ганбат агаарын хөлгийг хууль бусаар булаан авсан хүнд хүлээлгэх хариуцлагын талаар асуулт асууж, Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргил агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол соёрхон батлахыг дэмжиж байгаа бөгөөд уг гэмт хэргийг үйлдсэн хүнд хүлээлгэх хариуцлагыг тодорхой хуульчлах нь зүйтэй талаар саналаа илэрхийлсэн болно. Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протоколыг соёрхон батлах тухай*

хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 76.9 хувь нь дэмжсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг зөвшилцөх хэлэлцүүлэх тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Баярлалаа.

**Б.Энх-Амгалан:** Батамгалан гишүүнд баярлалаа.

Хуулийн төслийн талаарх танилцуулга болон Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэр өгнө үү? Баделхан гишүүнээр тасаллаа.

Баделхан гишүүн асуултаа асууя.

**Х.Баделхан:** Баярлалаа.

Би хуулийн төслийг дэмжиж байгаа юм. Тэгээд нэг асуулт байна. Энэ манай аймгийн нисэх буудалтай холбоотой би асуумаар байна. Энэ өргөтгөлийн барилгыг бол Иргэний нисэхээс яамнаас санаачлаагүй. Бид нар гишүүд өөрсдөө санаачлаад төсөв хийлгээд өнгөрсөн оны улсын төсөвт оруулсан компани шалгараагүй. Өнгөрсөн онд хийж чадаагүй. Энэ жил одоог хүртэл одоо компани шалгараагүй байна. Уг нь өнгөрсөн жил Ховдын нэг боломжийн компани орсон байсныг тэгээд гэрээ хийгээгүй одоог хүртэл шүүхээр маргаж байгаа юм байна.

Одоо ингээд наадам боллоо. Наадмын дараа намар. Тэгээд энэ жил ахиад л баригдахгүй байдалд хүрээд байна шүү дээ. Энэ одоо энийг яах вэ энэ туйлын хариуцлагагүй байна гэж би бодоод

байгаа. Бид өөрсдөө зураг төсвийг нь хийлгээд улсын төсөвт оруулаад одоо 2 дахь жилд явж байгаа. Одоог хүртэл компани нь шалгараагүй ажлаа эхлээгүй. Энэ туйлын хариуцлагагүй байна.

Одоо энийг яах юм бэ. Манай аймаг бол нөгөө ачааны каннер байхгүй. Өвлийн хүйтэнд бол хүмүүс гадаа гараад ачаа авдаг. Тэгээд иргэдээс тавьсан санал хүсэлтийн дагуу бид нар энийг улсын төсөвт оруулаад 2 дахь жилд явж байгаа. Энэ дээр одоо энэ ажил энд ер нь энэ жил дуусах юм уу ер нь ямар шатандаа байна гэж би Бямбацогт сайдаас асуумаар байна л даа.

**Б.Энх-Амгалан:** Бямбацогт сайдын микрофоныг өгье.

Хэлэлцэж байгаа асуудалтай хэдийгээр холбоогүй ч гэсэн сайд байж байгаа учраас хариулт өгчихье.

**С.Бямбацогт:** Баделхан гишүүний хэлж байгаа үнэн. Бас ИНЕГ-ын өмнөх удирдлагууд жоохон хариуцлагагүй хандаад өнгөрсөн жил шалгаруулсан компанитай гэр хийхгүй байсаар байгаад өнгөрсөн жил энэ ажил хийгдээгүй. Энэ жил дахиад тендер зарлаад компани ороогүй билүү эхнийхэд нь, компани ороогүй. Ингээд эхний тендер зарлалт нь амжилтгүй болсон. Сая 5 сарын 31-нээр гэрээ хийгдээгүй бүх ажлуудын төсвийг татна гэж асуудал яригдаад энийг одоо бас Засгийн газар дээр нэлээн яриа яриад 10 сарын 1 хүртэл одоо хугацааг нь сунгаж байгаа. Тийм болохоор одоо энэ хугацаанд дахиж тендерийг яаралтай зарлаад яаралтай зохион байгуулаад энэ ажлыг одоо бас гүйцэтгэж эзэнтэй болгох ийм асуудал яригдаж байгаа. Ийм байдлаар одоо асуудал шийдэгдэнэ гэдгийг танд хэлье. Ямар ч байсан эзэнтэй болчихно. Гэхдээ нөгөө хамгийн гол нь төсөвт өртөг тэгээд нөгөө үнийн өсөлттэй холбоотой бас нэг жоохон тодорхойгүй асуудал бас байсан юм байна лээ. Тэдгээр нь бас энэ ажлыг удааширахад бас нөлөөлсөн.

**Б.Энх-Амгалан:** Баделхан гишүүн тодруулъя.

**Х.Баделхан:** Өмнөх онд бол өөрсдөө шалгаруулаад ганц компани орсон байхад гэр хийгээгүй. Энэ оны хувьд бол төсөвт ямар нэгэн асуудал байхгүй шүү дээ. Төсвийн тодотголоор дахиад төсвийн хийсэн одоо энэ оны төсөвт ямар нэгэн асуудал байхгүй. Тийм учраас энийг татна гэсэн ойлголт байхгүй л дээ. Одоо ИНЕГ-ын хариуцлагагүй ажиллагаанаас болоод энэ чинь 2 дахь жил явж байна шүү дээ. Энийг одоо ажлын хурданд эхлүүлмээр байна.

**Б.Энх-Амгалан:** Бямбацогт сайд гүйцээгээд хариулчихъя Бямбацогт сайдын микрофоныг өгье.

**С.Бямбацогт:** Тийм. Өнгөрсөн жил бол жоохон асуудалтай байсан. Энэ жилийн хувьд асуудал байхгүй. Гэхдээ сая тендер зарлахад компани оролцоогүй. Тийм учраас одоо дахиж тендер зарлах бололцоотой байгаа. Дахиж тендер зарлаад одоо компаниуд идэвхтэй оролцоод бас өрсөлдөөн бий болоод л ингээд л эзэнтэй болох байх. Ямар ч байсан одоо эзэнтэй болгохын тулд ажиллаж байгаа. Өнгөрсөн жилийн хувьд бас нэг жоохон асуудалтай байсан юм байна лээ. Энэ жил бид ямар ч байсан бүх ажлуудыг одоо улсын төсөвт тусгагдсан бүх ажлуудыг бүрэн хэмжээнд одоо эхлүүлэх ийм л одоо зорилго тавиад ажиллаж байгаа.

Тийм болохоор хийгдчих байх эзэнтэй бол гэрээ байгуулаад хийгдчих байх гэж бодож байна. Түүнд анхаарч ажиллана Баделхан гишүүн ээ.

**Б.Энх-Амгалан:** Бямбацогт сайдад баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу? Алга байна.

Одоо санал хураалт явуулна аа.

Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт гишүүд ээ.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 63,6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Дараагийн асуудалдаа орно оо. Санал, дүгнэлтийг Бат-Амгалан гишүүн Улсын Их Хуралд танилцуулъя.

16.40 цагт

Дараагийн асуудалдаа орёе. Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенцод нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцье.

Түрүүчийн хуулийн төслийг хэлэлцэхэд оролцсон ажлын хэсэг өөрчлөгдөөгүй хэвээр байгаа. Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт танилцуулна. Бямбацогт сайдын микрофоныг өгье.

**С.Бямбацогт:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улс нь Олон улсын иргэний нисэхийн байгууллагын гишүүн улсын хувьд тус байгууллагын бодлого, стандарт, зөвлөмжийг хэрэгжүүлэх, гэрээ, конвенцод нэгдэх, аюулгүй ажиллагааны аудит, хамтын ажиллагааны төсөл хөтөлбөр сургалтад хамрагдах зэргээр олон улсын иргэний нисэхийн үйл хэрэгт оролцож байна. Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 2010 оны нисэхийн аюулгүй байдлын дипломат бага хурлаас иргэний нисэхийн эсрэг шинэ төрлийн аюул занал хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, илүү үр дүнтэй арга хэмжэ авахад

чиглэсэн эрх зүйн хэм хэмжэ бэхжүүлэх зорилгоор олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенцыг баталсан. Тус конвенц нь 2018 онд ...-ний өдрөөс эхлэх хүчин төгөлдөр болсон 34 улс одоогоор гарын үсэг зурсан. 23 улс соёрхон баталж, 19 улс нэгдсэн орсон байна.

Энэхүү конвенцод олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд дурдаагүй орхигдуулсан зохицуулалтууд түүнчлэн гэмт хэрэгт тооцох үйлдэл, ялын байдал, гэмт хэргийн оролцогчид, хэргийн харьяалал, гэмт этгээдийг шилжүүлэх, хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх асуудлыг нарийвчлан тусгасан бөгөөд Монгол Улсын 72 онд нэгдэн орсон Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай Мангалын конвенц, түүний нэмэлт протоколоос давуу хүчин чадалтай юм. Агаарын тээврийг либералчилж, нислэгийн тоо, чиглэлийг эрчимтэй нэмэгдүүлж байгаа энэ үед манай улс нь иргэний нисэхийн аюулгүй байдлын стандарт түвшнийг олон улсын шинэчлэн сайжруулсаар байгаа стандарт шаардлагад нийцүүлэх энэ төрлийн хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, хариуцлага хүлээлгэх тогтолцоог сайжруулах зайлшгүй шаардлага үүсээд байна. Монгол Улс нь олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенцыг соёрхон баталснаар иргэний нисэхийн аюулгүй байдлын түвшин эрх зүйн тогтолцоог сайжруулахад дэмжлэг болох бөгөөд улсын төсвөөс нэмэгдэл зардал шаардахгүй ээ.

Энэхүү конвенцын 1 дүгээр зүйлд гэмт хэрэгт тооцох үйлдвэрлэлийг тодорхой заасан бол 3 дугаар зүйлд 1 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт ял оногдуулахаар тусгасан.

Иймд хуулийн төсөлтэй холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27 дугаар бүлэгт нэмэлт, өөрчлөлт оруулахаар байгаа болно.

Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенцод нэгдэн орсныг Соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Б.Энх-Амгалан:** Бямбацогт сайдад баярлалаа.

Хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Энхтайваны Бат-Амгалан танилцуулна аа. Бат-Амгалан гишүүний микрофоныг өгье.

**Э.Бат-Амгалан:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Засгийн газар 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенцод нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төслийг зөвшилцөх хэлэлцүүлэх асуудлыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.4 дэх хэсэгт заасны дагуу Хууль зүйн байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Уг хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, уг хэлээгүй бөгөөд олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенцод нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 76.9 хувь нь дэмжсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенцод нэгдэн орсныг Соёрхон батлах тухай хуулийн төслийг зөвшилцөх

хэлэлцүүлэх тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Баярлалаа.

**Б.Энх-Амгалан:** Бат-Амгалан гишүүнд баярлалаа.

Хуулийн төслийн талаарх танилцуулга болон Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

Нямаагийн Энхболд гишүүнээр тасалъя.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслийн талаарх танилцуулга болон Хууль зүйн байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. Одоо санал хураалт явуулж эхэлье. Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенцод нэгдэн орсныг соёрхон батлах тухай

хуулийн төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Хуралдаанд 11 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 63.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд миний бие танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье. Гишүүд болон ажлын хэсэгт баярлалаа.

Хуралдаан өндөрлөлөө.

16.50 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА